



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 8/302

Улаанбаатар хот

┌ Нийслэлийн Худалдан авах ажиллагааны ┐
газрын хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн
бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 4,772,880 /дөрвөн сая долоон зуун далан хоёр мянга найман зуун наян/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Э.Болормаа/-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Э.Болормаа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050000813

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны ... дугаар сарын ... өдрийн ... дугаар тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар

д/д	Хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт хүчин чадал	Ашиглалтанд орсон огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хурмтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр		Төгрөгөөр
								Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлсэн данс	Бүртгэх данс	
Машин, тоног төхөөрөмж														
1	Факсын аппарат	Rapasonic KX-FT 981	Хэвлэгчтэй, дугаар илрүүлэгчтэй, автомат хариулах систем	2013.03.13	дунд	ш	1	150,000.0	150,000.0	150,000.0	-			
2	Агааржуулагч	Beiko	Цагаан, тавцантай, 90 литрийн багтаамжтай, тог зарцуулалт бага.	2013.08.14	дунд	ш	10	224,990.0	2,249,900.0	2,249,900.0	-			
3	Телевиз	Grandstream	Дэлгэцтэй, POE дэмжинэ, Lan сүлжээний холболттой	2013.03.11	дунд	ш	1	579,981.0	579,981.0	405,987.1	173,993.9			
4	Усны аппарат	I Kub	Усны түвшин мэдрэгчтэй, алсын удирдлагатай, чийгшүүлэгчтэй, сэс нь 3 хурдтай, 7 цагийн тохируулгатай, мөсөн сав бүхий сэрүүцүүлэгч	2013.07.31	дунд	ш	1	589,000.0	589,000.0	589,000.0	-	Тавилга эд хогшил		Тоног төхөөрөмж
5	Хөргөгч	Sharp	32 инчийн дэлгэцтэй, LCD	2013.03.11	дунд	ш	1	389,999.0	389,999.0	272,999.2	116,999.8			
6	Хөргөгч	WEGUARD	340*1100*375 хэмжээтэй, халуун хүйтэн устай, 4 шүүлтүүртэй.	2013.12.20	дунд	ш	2	407,000.0	814,000.0	507,749.8	306,250.3			
Машин, тоног төхөөрөмжийн дүн								4,772,880.0	4,772,880.0	4,175,636.0	597,244.0			